



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН
НЭР ДЭВШИГЧ ГАНТӨМӨРИЙН
ХАНГАРЬД ТАНАА**

2024.09.03 № ТНАО-2024/13-ЦНТА-НА-106

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч Гантөмөрийн Хангарьдын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

01321124


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Гантөмөрийн Хангарьд /РД: МП83031672 /-ын Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Гантөмөрийн Хангарьдын мөрийн хөтөлбөр (..... хуудас) -ийг хавсаргав.


Хувийг: Хүдэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ГАНТӨМӨРИЙН
ХАНГАРЬДЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Нэг: Төрийн байгууллагын ил тод байдлыг хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж ажиллана.

- 1.1 Орон нутгаас сонгогдсон нам эвслийн төлөөлөгчид болон төрийн албан хаагчидтай хамтран ажиллаж, сум, орон нутгаас гарч буй тогтоол, шийдвэр оновчтой, хэрэгжихүйц зөв боловсруулагдахад өөрийн мэдлэг, чадвараа дайчлан ажиллана.
- 1.2 Сум, багийн удирдлага, төрийн үйлчилгээний албан хаагчдын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага болон иргэдийн хамтарсан хяналт тавьж, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангаж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.
- 1.3 Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор улирал бүр багийн иргэдэд мэдээ мэдээллийг хүргэх ажлыг тогтмол зохион байгуулна.
- 1.4 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэж буй эсэхэд хяналт тавьж ажиллана.
- 1.5 Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоог хөгжүүлэх сан, төсөв санхүүгийн хөрөнгийг тодорхой үр дүнтэй үйл ажиллагаа, бүтээн байгуулалтад зарцуулж буй эсэхэд тавих олон нийтийн болон хөндлөнгийн хяналтыг сайжруулна.
- 1.6 Байгаль орчноо хамгаалах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, зэрлэг ан амьтан, байгалийн дагалт баялаг болох самар, жимс жимсгэнэ, бусад байгалийн дагалдах баялгаа хамгаалах, зохистой түүж бэлтгэхэд малчид болон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх бодлого баримтална.

Хоёр: Мал аж ахуй, газар тариалан, төмс хүнсний ногоо тарьж хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжихэд төрийн бодлогыг уялдуулан ажиллана.

- 2.1 Сүргийн бүтцийн зохистой харьцааг ханган МАА-г эрчимжүүлэн, хөгжүүлэх ажлыг дэмжиж, малчид, иргэдтэй хамтран ажиллана.
- 2.2 Сум орон нутгийн малчдад тулгамдсан нийтлэг асуудлыг шийдвэрлэх ажлыг холбогдох байгууллагад уламжлан, хамтран хэрэгжүүлнэ.
- 2.3 Мал аж ахуйн удмын санг сайжруулж, үржил селекцийн үйл ажиллагаа, мал сүргийн үүлдэр, угсаа, чанарыг сайжруулах ажлыг орон нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулна.
- 2.4 Газар тариалан эрхлэгчид болон малчин өрхийн хоорондын малын бэлчээр, хадлангийн талбайн зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 2.5 Сум орон нутагт өрхийн үйлдвэрлэл эрхэлж, хүнсний ногоо тарьж ургуулж байгаа иргэд, ногоочдын холбооны үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллана.
- 2.6 Өрх бүр хашаандаа хүнсний ногоо тариалж, хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

Гурав: Иргэн таны төрийн төлөөлөл учир хүлээсэн үүргээ ухамсарлан, иргэн танд ил тод төрийн үйлчилгээг үзүүлж ажиллана.

3.1 Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах таатай орчныг бүрдүүлэх боломжийг судалж, холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажиллана.

3.2 Төрийн ажлыг түргэн шуурхай, ил тод явуулах, албан тушаалын томилгоог улс төрөөс хараат бус байх зарчмыг баримтлан ажиллана.

